



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ**

Нийслэлийн Засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7799 0101

Цахим шуудан: ubhd@emg.ub.gov.mn
Цахим хуудас: www.ubhealth.mn

2023.12.24 № 10-15-02/026/821.

Зураг төсөлд эрүүл ахуйн
хяналт хийж зөвшилцсөн тухай

Танай компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 10-00/07 дугаартай “Барилга, байгууламж, барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийх тухай” удирдамжийг тус тус үндэслэн үндэслэн Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороонд баригдах Чингэлтэй дүүргийн онцгой байдлын хэлтсийн гал унтраах, аврах ангийн барилгын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлээ.

Барилга байгууламжийн нэр, зориулалт, баригдах :

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/816 дугаар захирамжтай, Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт олгосон нэгж талбарын 1500911167 дугаартай 0.21 га газартай, Нийслэлийн ерөнхий архитекторын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн МЗХ2023/24-009 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, батлагдсан загвар зурагтай.

Зураг төслийн товч агуулга :

Тус барилга нь 3 давхар тэнхлэгээрээ 27х39.65м хэмжээтэй барилга 1 дүгээр давхартаа гал унтраах машины зогсоол, гал тогоо хооллох заал, ариун цэврийн өрөө, оффис, чийрэгжүүлэлт, саун, душ, 2 дугаар давхартаа хурлын заал, оффис, ээлжийн ажилёидын унтлагын өрөө, эмчийн өрөө, ариун цэврийн өрөө, 3 айлын орон сууц, 3 дугаар давхартаа 3 айлын орон сууц зэргийг төлөвлөсөн.

Техникийн нөхцөл:

Мэдээлэл холбоо: Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн В-U2023/898 дугаартай техникийн нөхцөлтэй.

Цахилгаан хангамж: УБЦТС ТӨХК-ийн 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 01/01032/23 дугаартай техникийн нөхцөлтэй.

Дулаан хангамж: Цахилгаанаар

1150500931

Усан хангамж, бохир ус зайлуулалт: Өөрийн эх үүсвэртэй.

ДҮГНЭХ НЬ:

Ажлын зурагт дээрхи тайлбар, тодруулга хийснээр "Ориент плюс" ХХК-ийн боловсруулсан гал унтраах, аврах дугаар ангийн барилгын ажлын зураг нь эрүүл ахуйн шаардлагад нийцэж байна.

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд мэргэжлийн байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Та улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзвэл Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтын дагуу гомдол гаргах эрхтэй.

ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААРЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ 10-10/02/025 Б.ШИНЭДАВАА



ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ОРИЕНТ ПЛЮС ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Ц.БОЛДБААТАР